

Product Data Sheet

Version 31/08/2009 (corporate 15/04/2009)

Sika® MonoTop® -412 TH

Construction

Sika® MonoTop® -412 TH

Бүтээцийн засварын зуурмаг

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sika® MonoTop® -412 TH нь EN 1504-3 стандартын R4 ангилалын шаардлагад нийцсэн, хялгасан арматур агуулсан, дан бүрэлдэхүүн, агшилт багатай бүтээцийн засварын зуурмаг юм.

Хэрэглээ:

- Сэргээн засварлах ажилд тохиромжтой (EN 1504-9 стандартын 3.1 , 3.3 аргачлалын 3-р зарчимын дагуу). Барилга, гүүр, дэд бүтэц, дээд байгууламжуудын бетоны гэмтэл болон нуралтыг засварлахад хэрэглэнэ.
- Бүтээцийн хүчитгэлд тохиромжтой (EN 1504-9 стандартын 4.4 аргачлалын 4-р зарчимын дагуу). Бетонон бүтээцэд нэмэлт шавардлага хийснээр тулгуур хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Идэвхгүй бетонон эдлэлийг сэргээн хамгаална (EN 1504-9 стандартын 7.1 ба 7.2 аргачлалын 7-р зарчимын дагуу). Бохирдсон болон нүүрсхүчлээр баяжсан бетоныг нэмэлт шавардлага хийн хамгаалалтын бүрхүүлээр үүсгэн нөхөж өгнө.
- Идэвхтэй хөдөлгөөний ачаалал бүхий орчинд гүйцэтгэл хийж туршигдсан.

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Дээд зэргийн ажиллах чадвартай
- Гүйцэтгэлийг гараа болон машинаар хийх боломжтой
- Гүйцэтгэлийн үе давхрага тутмыг 50 мм хүртэлх зузаантай хийх боломжтой
- EN 1504-3 стандартын R4 зэрэглэлтэй
- Бүтээцийн засварт хэрэглэгдэх
- Сульфатад тэсвэртэй
- Маш бага хэмжээнд агшдаг
- Суурь түрхлэг шаардлагагүй
- Хлоридын нэвчилтэнд тэсвэртэй
- Гал тэсвэрийн A1 зэрэгтэй

The Sika logo consists of the word "Sika" in a bold, italicized, sans-serif font, with a registered trademark symbol (®) to its upper right. The text is white and is set against a red triangular background that points downwards.

Стандарт / Зөвшөөрлүүд

LMP – Laboratory of Material Preparation and Methodology, Beinwil, Switzerland
 Материал боловсруулалт аргачлалын лаборатори, Швейцарь улс – 2009 оны 04-р сарын 09-ний өдрийн EN 1504-3 стандартын А-32769-3Е туршилтын дүгнэлт.

Нэмэлт

2008 оны 07-р сарын 01-ний өдрийн Идэвхтэй хөдөлгөөний ачаалалт бүхий орчинд гүйцэтгэл хийсэн туршилт – (BAM) Bundesanstalt fuer Materialforschung und-pruefung – Pruefung von Instandsetznugsmoertel nr. VII.1/126904/1

Бүтээгдэхүүний мэдээлэл**Хэлбэр****Төлөв / Өнгө**

саарал өнгийн нунтаг

Сав баглаа боодол

20 кг-ийн цаасан ууттай

Хадгалалт**Хадгалах нөхцөл / хугацаа**

Үйлдвэрээс савлагдсан савлагаа гэмтэж цоороогүй, бүрэн бүтэн тохиолдолд хуурай сэрүүн орчинд 12 сар хүртэл хадгалах боломжтой.

Техникийн мэдээллүүд**Химийн суурь**

Сульфатад тэсвэртэй цемент болон сонгомол дүүргэгч болон нэмэлтүүд орсон

Нягт (+20°C орчинд)

шингэн зуурмагын нягт ~ 2,10 кг/л

Ангилал

хамгийн том диаметрийн хэмжээ : 2.0 мм

Үе давхрагын зузаан

хамгийн багадаа 6 мм/ хамгийн ихдээ 50 мм

Механик / физик шинж чанар

+20°C орчинд хийгдсэн лабораторын туршилтын үр дүн:

Шахалтын бат бэх

			(EN 196-1)
1 өдөр	7 өдөр	28 өдөр	
~15 кг/см ² (MPa)	~40 кг/см ² (MPa)	~50 кг/см ² (MPa)	

Гулзайлтын бат бэх

			(EN 196-1)
1 өдөр	7 өдөр	28 өдөр	
~4 кг/см ² (MPa)	~6 кг/см ² (MPa)	~8 кг/см ² (MPa)	

Агшилт

+20°C болон 65%ийн чийгшилтэй орчинд, 28 хоногт
 ~ 500 μm/m (EN 52450)

Дулаан тэлэлтийн коэффициент

10.5 x 10⁻⁶ m/m. °C (EN 1770)

Шаардлага

EN 1504-3 R4 зэрэглэлийн шаардлага (ус цементийн харьцаа 15%-д туршигдсан)

	Туршилтын аргачлал	Үр дүн (лабораторын орчинд)	Тавигдах шаардлага
Шахалтын бат бэх	EN 12190	56 N/mm ² (MPa)	> 45 N/mm ² (MPa)
Хлоридын ионы агууламж	EN 1015-17	< 0.005%	< 0.05%
Капилляр шингээлт	EN 13057	0.23 kg.m-2.h-0.5	< 0.5 kg.m-2.h-0.5

Нүүрсхүчлийн эсэргүүцэл	EN 13295	Тэнцэв	Хязгаарлалтаас бага
Е-модуль	EN 13412	30.9 kN/mm ² (GPa)	> 20 kN/mm ² (GPa)
Дулааны зохицол	EN 13687-1	2.4 N/mm ² (MPa)	> 2.0 N/mm ² (MPa)
1-р хэсэг: Хөлдөлт, гэсэлт			
Цавууны барьцалт	EN 1542	3.1 N/mm ² (MPa)	> 2.0 N/mm ² (MPa)
Дулааны тэлэлтийн коэффициент	EN 1770	10.5 X 10 ⁻⁶ m/m.°C	мэдэгдсэн хэмжээ

Системийн мэдээлэл

Системийн бүтэц

Sika® MonoTop® -412 нь Европын стандарт EN 1504-д нийцсэн Сика брендийн зуурмагын нэр төрөлд хамрагдах бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй:

Суурь түрхлэг / Зэврэлтийн хамгаалалт:

- SikaTop® Armatec® 110 EpoCem® : Шаардлагын дагуу

Засварын зуурмаг:

- Sika® MonoTop® -412 TH : Гараар болон машинаар гүйцэтгэх бүтээцийн засварын зуурмаг (R4 төрөл)

Өнгөлгөөний түрхлэг

- Sika® Refit нэрийн бүтээгдэхүүнүүд : Нүх сүвийг битүүлж, тэгшлэх зуурмаг

Хэрэглээний мэдээлэл

Зарцуулалт

Зарцуулалтын хэмжээ нь гадаргуун тэгш байдал болон үе давхрагын зузааны хэмжээнээс хамаарна. Жишээ нь: 1 м² талбайд, 1 см тутамд, ойролцоогоор 18 кг нунтаг бүтээгдэхүүн хэрэглэгдэнэ. 20 кг-ийн савлагаатай бүтээгдэхүүн нь ойролцоогоор 13,7 литр зуурмаг болно.

Гадаргуун чанар

Бетон:

Бетоны гадаргуу тоос шороо, тос тосоол г.м урвалд орж барьцалдах шинж чанарт сөрөг нөлөө үзүүлж болохуйц бодис болон элдэв сул хэсэггүй бат бэх байх шаардлагатай.

Ган төмөр хүчитгэл:

Барьцалдах шинж чанарт сөрөг нөлөө үзүүлэх, зэврэлт үүсгэж болзошгүй материалууд болон зэврэлт, шохойжилт, бетон болон зуурмагын тоосжилт, сул эд хэсгүүдээс бүрэн ангид цэвэр байх шаардлагатай.

Тодорхой шаардлагуудыг EN1504-10д тусгагдсаны дагуу хангах.

Гадаргууг бэлдэх / Суурь түрхлэг

Бетон:

Гэмтэлтэй, бат бэх муутай, нурж буй болон шаардлагатай тохиолдолд бат бэх бетоныг ч тохирох арга барилын дагуу хуулах хэрэгтэй.

Ган төмөр хүчитгэл:

Гадаргууг зүлгүүр бүхий үлээгч цэвэрлэгч болон даралтад усаар шүрших аргачлалаар сайтар цэвэрлэнэ.

Суурь түрхлэг:

Ерөнхийдөө сайтар бэлтгэж, тэгшилсэн гадаргууд суурь түрхлэгийг түрхэх шаардлагагүй. Энэ тохиолдолд гадаргууг зөвхөн сайтар чийглэж өгөхөд хангалттай. Гадаргуун чийгшлийг хатаагүй байх үед нь засварыг

шавардлагыг хийж өгнө. Өөрөөр хэлбэл, гадаргуу дахь нүх сүвэнд ус тогтоогүй байж, гялтгасан биш бараан өнгөтэй харагдах ёстой.

Суурь түрхлэг түрхэх шаардлагатай тохиолдолд Sika® MonoTop® -412 TH бүтээгдэхүүнээ ердийнхөөс илүү шингэн зуурч, гадаргуу дээр ширүүн үстэй багсаар жигд сайн түрхэж өгнө. Суурь түрхлэгээ чийгтэй байх үед нь засварын шавардлагаа хийж өгнө.

Хүчитгэлийн түрхлэг:

Хаалт хэлбэрээр хүчитгэлийн түрхлэг түрхлэх шаардлагатай тохиолдолд (жишээ нь, гадаргууг хангалттай хэмжээний бетоноор бүрээгүй) SikaTop® Armatec® -110 EpoCem® (дэлгэрэнгүй мэдээллийг бүтээгдэхүүний техникийн хуудаснаас үзнэ үү) бүтээгдэхүүнийг ил гарсан арматурыг бүхэлд нь 2 үе давхарлан түрхэнэ.

Хэрэглэх нөхцөл / Хязгаарлалтууд

Гадаргуун температур хамгийн багадаа +5°C / хамгийн ихдээ +35°C орчинд

Орчны температур хамгийн багадаа +5°C / хамгийн ихдээ +35°C орчинд

Хэрэглэх заавар

Хольцын харьцаа 20 кг нунтаг бүтээгдэхүүнийг ойролцоогоор 2.9 – 3.1 литр усанд хольно.

Холих Sika® MonoTop® -412 TH бүтээгдэхүүнийг гараар холих бол, бага хурдтай (минутанд <500 эргэлттэй) цахилгаан холигч ашиглан хольно. Их хэмжээтэй холих бол албадмал бетон зуурагчид, түүний хэмжээнээс хамаараад 2-3 ба түүнээс дээш цаасан ууттай бүтээгдэхүүнийг нэг дор хийж хольж болно. Заасан хэмжээний усыг тохирох саванд хийнэ. Алгуурхан холих явцдаа дээрээс нь нунтаг зуурмагаа хийж өгнө. Зуурмагыг нэгэн жигд болтол хамгийн багадаа 3 минутын турш сайтар хольно.

Гүйцэтгэх аргачлал / Багаж тоног төхөөрөмж

Sika® MonoTop® -412 TH –ийг уламжлалт гар аргаар болон шингэн шүршигч тоног төхөөрөмжийг ашиглан механик аргаар гүйцэтгэх боломжтой.

Суурь түрхлэгийг чийгтэй, наалдамхай байх үед засварын шавардлагыг дээрээс нь сайтар дарж, барьцалдуулж өгөх шаардлагатай. Засварын шавардлагыг гараар хийхдээ гадаргуу дээр шавардлагын зуурмагаа нийвийгээр сайтар нягтаршуулан дарж өгөх хэрэгтэй. Гар аргаар болон механик аргаар хийх засварын шавардлагын аль алинд ч тохирох өнгөлгөөг гадаргуун шавардлага хатаж эхлэх үед хийж өгнө.

Цэвэрлэгээ Ажил дууссаны дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ усаар цэвэрлэнэ. Багаж дээр хатсан зуурмагыг зөвхөн механик аргаар л цэвэрлэх боломжтой.

Нээлттэй байх хугацаа +20°C орчинд ойролцоогоор 40 минут

Анхаарах зүйлс

- Sika® MonoTop® системийг ашиглан бетоны засварыг хийх Аргачлалын тодорхойлолт болон EN1504-10д тусгагдсаны дагуу гадаргуун бэлтгэлийн талаарх дэлгэрэнгүй зааварчилгаатай танилцана уу,
- Засварын гүйцэтгэлийг нарны шууд тусгалтай болон хүчтэй салхитай орчинд хийхээс татгалзана уу,
- Заагдсан хэмжээнээс илүү хэмжээний ус хэрэглэхгүй байх
- Зөвхөн сайтар бэлдсэн, бат бэх гадаргуу дээр засварын

шавардлагыг хийх,

- Гадаргуун өнгөлгөөний ажлын гүйцэтгэлийн явцад нэмэлт ус хийж болохгүй. Энэ нь гадаргуу дээр толбо болон хагарал үүсгэх магадлалтай.
- Шинэ цутгасан шавардлагыг бэхжилтээ авахаас өмнө хөлтөлтөөс хамгаал
- Таазны шавардлагыг гар ажиллагаагаар гүйцэтгэх үед үе давхрагыг хамгийн багадаа 6 мм, хамгийн ихдээ 30 мм –ийн зузаантай гүйцэтгэнэ.

Арчилгаа

- Шинэ цутгасан шавардлагыг бэхжилтээ авахаас өмнө шингэний дутагдалд оруулахаас сэргийлж зохих арчилгааг хийж өгч хамгаална.

Дүгнэх

- Энэхүү Техникийн зааварчилгаанд дурьдагдсан үзүүлэлтүүд бүгд лабораторын туршилтанд үндэслэгдсэн болно. Бодит үзүүлэлтүүд нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болохыг анхаарна уу.

Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны мэдээлэл

- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны болон физик, хими, байгаль орчны бусад нарийн мэдээллүүд бүтээгдэхүүний Эрүүл ахуй, Аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан болно.

Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Sika (Thailand) Limited

Head Office
700/37 Moo 5 Bangpakong Industrial Park II,
Km.57 Bangna-Trad Rd., T.Klongtamhru,
Muang District, Cholburi 20000

Tel: +66 3821 4270-85
Fax: +66 3821 4286
E-mail: sikathai@th.sika.com
website: <http://www.sika.co.th>



Sika®